

«Монголын нууц товчоо» нь XIII зууны үеийн Монголын түүх, уран зохиолын хосгүй нандин сурвалж, дурсгалт бичгийн нэг билээ. Тийм учраас дэлхийн олон түүхч, судлаачдын анхаарлыг татсаар иржээ. Дэлхийн олон эрдэмтний анхаарлыг ийнхүү татах болсон уг сурвалж нь чухамдаа нэрт монголч эрдэмтэн Владимирцовын онож хэлсэнчилэн «Дундад зууны үед нэг ч үндэстэн Монголын адилаар түүхч нарын анхаарлыг татсангүй гэж хэлж болох бол бас Нууц товчооны адилаар жинхэнэ амьдралыг тодорхой дүрслэн үзүүлсэн дурсгалт бичгийг нэг ч нүүдэлчин үндэстэн үлдээгээгүй»<sup>1</sup> байгаад оршино.

XX зууны эхэн үеэс Японд «Монголын нууц товчоог» судалж олон ном зохиол бичжээ.

Японы эрдэмтэн Нака Мичиёо (1851 — 1908) «Монголын нууц товчоог» хятад хэлнээс, япон хэлнээ хөрвүүлэн 1907 онд (Мэйжигийн 40 он) тайлбарын хамт «Чингисү кан жицүроку» («Чингис хааны үнэн тэмдэглэл») нэртэйгээр хэвлүүлсэн нь Япон улсад монгол судлал, түүний дотор «Монголын нууц товчоог» судлах анхны эх үүсвэрийг тавьжээ. Чухам ингэж Японд «Монголын нууц товчоог» судлах ажлын эхлэлийг нангиадач эрдэмтэн Нака Мичиёо тавьжээ. Тэрээр 1901 онд «Хятадын түүхийн нэвтэрхий толь-д Монголын Юан гүрний түүхийг бичих завсар хятадын түүхч Вэн Тинши-гээс «Нууц товчооны» нэгэн хувилбарыг хуулбарлуулан авч, монгол хэл сурахад ашиглажээ. Түүнээс хэдэн жилийн дараа буюу 1907 онд уг зохиолын бүрэн эхийг орчуулж дуусгаад удиртгал, тайлбарын хамт «Чингис хааны үнэн тэмдэглэл» нэртэйгээр хэвлүүлсэн байна. Нака Мичиёогийн орчуулгын гар хуулбар одоо эрдэмтэн Ивамура Шинобү-гийн хувийн номын санд хадгалагдаж байгаа ажээ. Түүнээс хойш Япон монгол судлалын ажлыг ихэд сонирхон судалж «Монголын нууц товчоо»-г хэл, түүх, уран зохиолын талаас нь судлах явдал өргөн цар хүрээтэй болжээ. Японы монголч эрдэмтэд «Нууц товчоо»-г «Монгол угсаатанд холбогдох түүхийн судалгааны сурвалж материалуудын дотроос хамгийн шилдэг, анхдагч эх бичиг»<sup>2</sup> гэж үзээд судалгааныхаа ажлыг нарийн дэс дараатай хийж иржээ. Өнөөгийн байдлаар Япон улсад «Монголын нууц товчоо»-той холбоо бүхий судалгааны ном зохиолын тоо улам олширч байна.

Нака Мичиёогийн бүтээлийг залгамжилж Ширатори Куракичигийн «Галиг үсгээр буулгасан “Монголын нууц товчоо» «Оняку мообүн гэн чио хишши» Токио, 1943), Кобаяши Такаширогийн «Монголын нууц товчоо» («Мооко хиши») зэрэг судалгааны бүтээлүүд дараалан хэвлэг-

<sup>1</sup> Владимирцов Б. Я. Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм, Л., 1934, стр. 6.

<sup>2</sup> Ш. Озава «Монголын нууц товчооны бүрэн тайлбар» (тэргүүн дэвтэр) Токио 1984, 3-р тал

дэж Нака Мичиёогийн дээрх номыг ч 1945 оноос хойш хоёр дахин хэвлэн гаргасан байна. Эрдэмтэн Ивамура, Фүжиэда нарын 1973 онд эмхэтгэн хэвлүүлсэн монголын судлалын талаар Японы эрдэмтдийн 1900 — 1970 онд бичсэн эрдэм шинжилгээний ном өгүүллийн жагсаалтаас үзвэл дурдсан хугацаанд Япон улсад «Монголын нууц товчооны» талаар эрдэм шинжилгээний 10 гаруй ном бүтээл, 70 гаруй өгүүлэл шүүмж бичигджээ. Японд «Монголын нууц товчоо»-г судалж доривтой бүтээл туурвисан эрдэмтэд гэвэл дээр дурдсан Ширатори Куракичи, Кобаяши Такаширо, Ивамура Шинобү, Хаттори Широ, Озава Шигэо, Мураками Масацугу, Мураяма Шичиро нар юм. Эдгээр эрдэмтэд «Нууц товчоог» түүх, хэл шинжлэл, утга зохиол, соёл, угсаатны зүй гэх мэт олон чиглэлээр судалжээ.

Япон дахь Монголын нууц товчоо» судлалыг хоёр үе болгон авч үзэж болмоор санагдана. Нэгдүгээр үе нь Нака Мичиёогийн орчуулж тайлбарлан, Японы уншигч олонд танилцуулсан 1907 оноос 1950 он хүртэл, хоёрдугаар үе нь 50-иад оноос одоо хүртэлх үеийг тус тус хамаарах ажээ. Эхний үед Хаттори Широ, Кобаяши Такаширо, Итихама Жүнтаро нарын зэрэг цөөн тооны судлаачид ажиллаж байж. Тэд «Нууц товчоог» жинхэнэ эрдэм шинжилгээний үүднээс судлах ажилд гүнзгийрэн орох бэлтгэл хийж гол хүчээ түүний орчуулгыг чанаржуулахад чиглүүлж байсан бололтой. Тийм ч учраас К. Ширатори, Т. Кобаяши нарын доривлог орчуулга энэ үед гарч ирсэн байна.

50-иад оноос хойш «Нууц товчоог» судлах ажлын цар хүрээ өргөнжиж, судлан шинжээчдийн эгнээ ч нэмэгджээ. 50-иад оноос эхлэн «Нууц товчоо»-г Хаттори Широ, Абэмацу Гэньичи, Озава Шигэо, Мори Масао, Мураками Масацугу нар хэлний талаас нь, Ширатори Куракичи, Ивамура Шинобү нар түүхийн талаас нь, Кобаяши Такаширо, Хасуми Харуо зэрэг хүмүүс түүх, утга зохиолын талаас нь тус тус судалж, судалгааны нэлээд бүтээлүүд туурвисан байна. Тухайлбал, Кобаяши Такаширо «Монголын нууц товчооны судалгаа» (Токио, 1954, 432 х.), «Чингис хаан» (Токио, Иванами шиншо хэвлэлийн газар, 1965, 236 х.), Ивамура Шинобу «Монголын нууц товчоо—Чингис хааны үнэн түүх» (Токио, Чюо коронша хэвлэлийн газар, 1963, 203 х.), «Монголын нууц товчоо» (Токио, Чоо коронша хэвлэлийн газар, 1977), Мураками Масацугу «Монголын нууц товчоо (Чингис хааны тухай үлгэр)» (3 дэвтэр, Токио, 1970, 1972, 1976), Озава Шигэо «Монголын нууц товчооны бүрэн тайлбар» (тэргүүн дэвтэр, Токио, 1984, 503 х.) гэх зэрэг бүтээлүүд орно.

Монголын эртний түүх, «Монголын нууц товчоо», «Алтан товч» зэрэг зохиолыг 30-аад оноос эхлэн олон жил судалсан эрдэмтэн Кобаяши Такаширо 1955 онд Монголын нууц товчооны судалгаа» гэдэг эрдэм шинжилгээний бүтээл туурвиж утга зохиолын ухааны доктор болжээ. Кобаяшигийн бичсэн энэхүү бүтээл нь сүүлийн үед «Нууц товчооны» талаар гарсан томоохон бүтээлүүдийн нэг юм. Кобаяши энэ бүтээлдээ «Нууц товчоог» түүх болон утга зохиолын талаас нь нарийвчилан судалжээ. Энэ бүтээл 11 бүлэг, 36 зүйлтэй. Номын оршил хэсэгт «Нууц товчоог» судалж ирсэн түүхийг дэлгэрэнгүй бичжээ. Эхний бүлэгт хааны ордны үнэн тэмдэглэл, улсын түүх, товчоон зэргийн ялгаврыг гаргаж «Нууц товчоог» «Алтан дэвтэр», «Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл» зэрэг зохиолтой харьцуулан судалжээ. Дараагийн бүлгүүдэд «Нууц товчоо» гэдэг нэрийн судалгаа, «Нууц товчоо»-г бичсэн он цаг, хятад хэлнээ хэзээ, хэрхэн орчуулсан болохыг тодруулан судалсан байна.

Зохиогч номынхоо удаах бүлгийг дундад зууны үеийн монгол хэлний зарим нэгэн асуудлуудад зориулжээ. Мөн Монголын нууц товчоо»-ны

орчуулгыг хийхдээ XIII зууны үеийн монгол үгийг нэлээд хэмжээгээр хадгалж үлдсэн дагуурын аман аялгууг баримтлах нь зүйтэй гэсэн санал дэвшүүлсэн байна. Кобаяши дундад зууны үеийн монгол хэлийг судалсан нэрт эрдэмтэн Владимирцов, Поппе нарын судалгааны бүтээлүүдээс иш татаж өөрийн дүгнэлтийг бататгасан байна.

Эрдэмтэн Т. Кобаяши энэ бүтээлдээ Японд «Чингис хааны үнэн тэмдэглэл»-ийг орчуулснаас хойш явуулж ирсэн судалгааны үр дүнг нэгтгэн авч үзээд нэлээд тодорхой дүгнэлт өгч судалгааны ажлын цаашдын төлөвийг авч үзсэн байна. Японы монгол судлалын эхийг тавьсан эрдэмтэн Нака Мичиёогийн орчуулан тайлбар хийж 1907 онд хэвлүүлсэн «Чингис хааны үнэн тэмдэглэл»-ийг Т. Кобаяши өндөр үнэлж «эрдэм шинжилгээний ажилтан бүр урт удаан хугацааны турш хүндлэн ашиглаж болох үнэхээр гайхмаар шилдэг тайлбар бүхий нэн их ач холбогдолтой хөдөлмөр болсон»<sup>3</sup> гэж тэмдэглээд монгол хэлнээс орчуулсан орчуулгыг нь эрхбиш хянуур хандаж судлах хэрэгтэйг дурджээ.

Т. Кобаяши дээрх бүтээлээсээ гадна «Сүүлийн 10 жилд «Монголын нууц товчооны талаар хийсэн судалгаа» («Шигаку зашши» 61—1, 1952), «Профессор Пеллиогийн латин үсгээр галиглаж буулгасан Монголын нууц товчооны тухай», «Хэйнишийн орчуулж тайлбарласан. Нууц товчоо» зэрэг нэлээд тооны судалгааны өгүүлэл, шүүмж бичжээ. Т. Кобаяши нь өөрийн орны төдийгүй «Нууц товчооны» судлал хөгжсөн орнуудын эрдэмтдийн энэ чиглэлээр туурвисан судалгааны бүтээлүүдийг анхааран судалж, судалгаа шинжилгээний ажилдаа өргөн ашигладаг болох нь түүний бүтээлүүдээс тодорхой харагдаж байна. Энэ нь ч түүний судалгааны ажлын үнэ цэнийг аяндаа өргөж байна.

Т. Кобаяши-гаас гадна «Нууц товчоог» түүхийн талаас нь судалсан хүмүүс гэвэл Ш. Ивамура, К. Ширатори, О. Ямагучи, М. Мураками, Ж. Ёшида, Н. Тамура нар юм.

Эрдэмтэн Ш. Ивамура «Монголын нууц товчоо» гэдэг номоо 1963 онд хэвлүүлжээ. Зохиогч 12 бүлэг бүхий энэхүү номдоо «Монголын нууц товчоо»-г 1240 онд уйгур юм уу эсвэл монгол хүн уйгур жин монголоор бичиж 1240 оноос хойшхи үйл явдлыг дүрсэлсэн 11, 12-р бүлгийг хожим нэмж бичсэн гэж дурджээ. С. Ивамурагийн энэхүү санал нь «1908 онд Хятадын нэг эрдэмтэн Ей Дэхуй оршил бичиж гаргасан Юан гүрний үеийн дармал Нууц товчооны эхэд 12 дэвтэр байна. Энэ нь чухам үнэн хуваарь нь мөн бөгөөд тэргүүн арван дэвтэр нь урьд зохиогдсон ба дараа нэмсэн нь хоёр дэвтэр болно ...»<sup>4</sup> гэсэн академич Ц.Дамдинсүрэнгийн саналтай үндсэндээ тохирч байна. С. Ивамура үзэхдээ «номын нэрийг өгсөн явдал ч хожмын хэрэг бөгөөд Юан гүрэн мөхөж, Мин улс тогтсон үетэй холбоотой: «Нууц товчоо»-ны жинхэнэ нэр нь «Чингис хааны уг гарал» гэж байсан бөгөөд түүн дээр 11, 12-р бүлгүүдийг нэмж оруулахад шинээр «Монголын нууц товчоо» гэж нэрлэн улмаар энэ үеэс хойш хятад хэлээр орчуулагдан... иржээ»<sup>5</sup> гэж бичжээ. Зохиогч «Нууц товчоо»-г 1370 оноос Хятадад монгол хэл сурах гарын авлага болгож ханз үсгээр (утга) орчуулжээ... гэж үзээд уг ном XIV—XVI зууны үеийн монгол хэл сурах, судлах, Юан улс болон түүнээс өмнөх үеийн Монголын түүхийг судлах, мөн тухайн үеийн ханз үсгийн дуудлага, хятад аман аялгууг судлахад үнэт чухал хэрэг лэгдэхүүн мөн хэмээн тодорхойлжээ.

<sup>3</sup> Т. Кобаяши «Монголын нууц товчооны судалгаа» Токио, 1954, 15-р тал 4 «Монголын нууц товчоо» УБ., 1976, 5—6-р тал

<sup>5</sup> Ш. Ивамура «Монголын нууц товчоо Чингис хааны үнэн тэмдэглэл» Токио, 1963, 2-р тал

Монголч эрдэмтэн Ш. Ивамура «Нууц товчоо»-г «нүүдэлчин ард түмний аж байдлыг тусгасан утга зохиолын хамгийн их үнэ цэнэтэй ховор нандин бүтээл юм»<sup>6</sup> гэж үнэлсэн байна.

Зохиогч «Нууц товчоо»-ны судалгаандаа тулгуурлан 1965 онд «Монголын их эзэнт гүрэн» (хамтын бүтээл, Токио, Жинбүшү райша хэвлэлийн газар), 1968 онд «Монголын нийгэм эдийн засгийн түүхийн судалгаа» (Киото, 581 х.) зэрэг хэд хэдэн судалгааны бүтээл хэвлүүлсэн 10 м.

«Монголын нууц товчоо»-г хэлний талаас нь судлах ажлыг 40-өөд оноос эрдэмтэн Хаттори Широ хийжээ. Тэрээр «Монгол хэлээр бичсэн Монголын нууц товчооны нэгэн бүлгийн тухай» («Мооко» 1940-2), «Монголын нууц товчооны эх гэдэг дөрвөлжин үсгийн эх бичгийн тухай» («Гэнго кэнкю» 19, 20 1951). «Монголын нууц товчооны эх бичгийн асуудалд» гэх зэрэг хэд хэдэн судалгааны өгүүлэл бичжээ. Дараа нь «Монголын нууц товчооны монгол үгийг илэрхийлсэн хятад үсгийн судалгаа» (Токио, 1946, 146 х.) хэмээх судалгааны чамбай бүтээл хэвлүүлэв. Энэ бүтээл нь Япон улсад «Монголын нууц товчоог» анх түрүүн монгол хэлний талаас нь судалсаныхаа хувьд нэлээд ач холбогдолтой болсон байна.

Хаттори Широ энэ номдоо Юан гүрний үеийн хятад үсгийн дуудлага, ялангуяа тухайн үеийн монгол хэлний дуудлагыг нарийвчлан судлах ажилд ихээхэн хүч хөдөлмөр зарцуулжээ.

«Нууц товчоо»-г хэл шинжлэлийн талаас нь судалж судалгааны нэлээд өгүүлэл бичсэн бас нэг япон эрдэмтэн бол монгол судлаач Озава Шигэо юм. Тэрээр «Нууц товчооны монгол хэлний үйл үгийн-*rip* нөхцлийн тухай» (Токиогийн гадаад хэлний дээд сургуулийн мэдээ, 1952), «Нууц товчооны монгол хэлний -*ri* нөхцлийн тухай» (Токиогийн гадаад хэлний дээд сургуулийн мэдээ 3, 1953), «Нууц товчооны үйл үгийн-*bi*, *liqi*, *li i* нөхцлийн тухай», «Дундад зууны үеийн монгол хэлний нөхцлийн хэлбэрүүд» («Гэнго кэнню» 1960), «Нууц товчооны монгол хэлний судлал», «Монголын нууц товчоон дахь «*oki*» гэдэг үгийн тухай», «Нууц товчооны үйл үгийн зарим дагаврын тухай» гэх зэрэг олон тооны судалгааны өгүүлэл бичиж XIII зууны үеийн монгол хэлийг орчин цагийн Монгол хэлтэй харьцуулан судалжээ. «Монголын нууц товчоон дахь «*oki*» гэдэг үгийн тухай өгүүлэлдээ дундад зууны үеийн монгол хэлэнд *morí-morín usu-usun* гэх зэрэг тогтворгүй «-н» гэгддэг нэг хэсэг нэрийн үндэс байхын зэрэгцээ эгшгээр төгссөн нэр үгийн үндсэнд «н»-тэй, «-н»-гүй хоёр зүйлийн үндэс байжээ гэдгийг дурдаад үүнийгээ «Нууц товчоо»-ны хэлний жишээн дээр тайлбарлан «-Н»-тэй үндэс нь (*okin, qan, kü ün irgen* г. м.) тухайн хам бүтцийн дотор нэгэнт мэдэгдэж байгаа тодорхой зүйлийг зааж, «-н-гүй үндэс нь (*oki, qa kuu, irge* г. м.) уул хам бүтцийн доторх ямар нэгэн тодорхой биш зүйлийг зааж байна гэсэн санааг гаргажээ.

Мөн «Нууц товчоо» -ны үйл үгийн зарим дагаврын тухай гэдэг өгүүлэлдээ хуучин монгол хэлэнд тухайлбал XII—XIV зууны үед -*bi*, -*liqi*, -*jiqi*, *i* гэсэн дагаврууд нь эм хүйсийг заах утгаар хэрэглэгдэж байсан тухай дурджээ.

Үүнээс гадна Озава Шигэогийн Монголын нууц товчооны бүрэн тайлбар» (тэргүүн дэвтэр) зохиол 1984 онд Токиод хэвлэгдэн гарлаа. Энэ бүтээл сүүлийн үед «Нууц товчоо» судлалын талаар Японд гарсан томоохон бүтээл болох тухай өмнө нэгэнт өгүүлсэн билээ. Зохиогч но-

<sup>6</sup> Мөн тэнд 4-р тал

мынхоо оршилд: «Миний хувьд ханз үсгийн дуудлагаар орчуулсан монгол хэлний байдлыг тайлбарлах нь илүү чухал байв. Миний судалгааны гол талбар бол чухамхүү тэр үеийн монгол хэл юм»<sup>7</sup> гэж тэмдэглэжээ.

Зохиогч тэргүүн дэвтэртээ ханз үсгээр бичсэн «Нууц товчооны» эхний бүлгийн орчуулга, тайлбар, хуучин монгол бичиг, дөрвөлжин үсгээр өөрийн бичсэн бүлэг уг бүлгийн эгшгээр эхэлсэн үгийн хэсгийг оруулжээ. Номын оршилд «Нууц товчоо» судлалын тоймыг товч танилцуулсан байна.

Эрдэмтэн Ш. Озава цаашид «Нууц товчоо»-ны 12 бүлгийн орчуулгыг хуучин эхтэй нь тулган «Монголын нууц товчооны монгол хэлний толь бичиг», «Нууц товчооны монгол хэлний дүрмийг дараалан бичиж хэвлүүлэх зорилт тавин ажиллаж байгаа юм байна.

Монголч эрдэмтэн Озава энэхүү судалгааны бүтээлдээ «Нууц товчоо»-ны талаар доривтой судалгаа хийсэн эрдэмтэд болох Е. В. Кливез, Э. Хэйниш, Ш. Хаттори, А. Лигети, П. Пеллио, Н. Поппе, Ц. Дамдинсүрэн, С. А. Козин нарын орчуулга тайлбараас өргөн ашиглаж харьцуулалт хийсэн байна. Түүнчлэн хэл шинжлэлийн талаар гарсан гол гол бүтээлүүдийг ч анхааран нэлээд гүнзгий ул суурьтай судалгаа явуулсан байна. Энэ бүхэн түүний судалгааны ажлын бас нэг снцлог ололттой тал нь болсон юм.

Дээрх бүтээлүүдээс гадна Абэмацу Гэньичи «Хятад үсгийн дуудлагаар орчуулсан Монголын нууц товчооны монгол найруулгын тухайд», Мори Масао «Монголын нууц товчоонд гарч байгаа «овог» гэдэг үгийн тухай», Мураяма Шичиро «Монголын нууц товчооны ha'u!, qa'u! гэдэг хоёр үгийн тухай», Мураками Масацугу «Монголын нууц товчоо ба орчин цагийн халх монгол хэл», Ёшида Жүньичи «Монголын нууц товчооны түүхэн шинж чанар», Тамура Ницузо «Монголын нууц товчоонд монгол угсаатны уг гарлын тухай бичсэн нь» гэх зэрэг олон тооны судалгааны өгүүлэл гарлаа.

Японд «Монголын нууц товчоо»-г судалсан болон судалж байгаа ерөнхий тоймыг товчоор өгүүлбэл ийм байна. Японы монголч эрдэмтдийн эдгээр судалгааны бүтээлүүд нь хэдийгээр «Нууц товчоо»-г гүнзгийрүүлэн судалсан монгол, Зөвлөлтийн эрдэмтдийн бүтээлийг нягтлан үзээгүй талтай боловч «Нууц товчооны» судлалыг олон чиглэлээр хөгжүүлэхэд тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж байна.

<sup>7</sup> Ш. Озава «Монголын нууц товчооны бүрэн тайлбар» (тэргүүн дэвтэр) Токио, 1984, 3-р тал